

**ХЭЛНИЙ НӨХӨХ, ҮЛ НӨХӨХ БАЙРЛАЛЫН
ТУХАЙ АСУУДАЛД ***

Ш.Лувсанвандан

Хэлийг хүн яаж хэлдгээр нь судлах хэрэгтэй, хэлэнд хэлбэр нь анхдагч, хэрэглэх нь хоёрдогч, хэлний нэг хэсэг нь нөгөөтэйгээ нягт шүтэн барилдсан байдаг. Хэл бол хувирахын явцад гарах тогтонги чанар мөн гэх мэтийн хэдэн үндсэн зарчим дээр үндэслэн бүтэц хэлшинжлэлийн америкийн чиглэл буюу товчоолох хэл шинжлэл \дескриптивная лингвистика\ буюу байрлал хэл шинжлэл \дистрибутивная лингвистика\ гэгч гарч ирсэн байна.

Байрлал хэл шинжлэл нь хэлийг судлахдаа фонем судлалын түвшин, морфем судлалын түвшин гэх мэтээр хэд хэдэн түвшин болгоод дараагаар нь түвшин бүрийн хэмжээнд зохих материалаа хэсэглэж тэр хэсгүүдээ байрлалаар нь үндэс болгон анхдагч нэгжүүдийг нь тогтоодог байна. Ингээд фонем судлал\фонологи\-ын үндсэн нэгж нь фонем, морфем судлал\морфологи\-ын үндсэн нэгж нь морфем гэж тогтоосон байна.

Байрлал хэл шинжлэл нь нэг адил фонем буюу морфемын янз бүрийн хувилбар болох уу, эсвэл тус тусдаа биеэ даасан өөр өөр фонем буюу морфем болохыг зохих фонем, морфемын байрлалаар тогтоох аргыг боловсруулсан байна. Энэ аргын ёсоор бол ямарваа хоёр авиа нэгийнхээ тохиолдох байранд нөгөө нь тохиолдохгүй байвал тэр хоёр авиа нэг фонемын хоёр хувилбар байж, тэгж тохиолдож байвал тус тусдаа биеэ даасан хоёр фонем болох ёстой ажээ. Биеэ даасан тус тусдаа морфем буюу нэг морфемын янз бүрийн хувилбар болохыг мөн энэ аргаар ялган тогтоох болсон байна. Хэл шинжлэлийн дурдсан чиглэлд хэлний ямарваа хоёр элементийн нэг нь нөгөөгийнхөө байранд үл тохиолдох шинжийг нь нөхөх байрлал \дополнительная дистрибуция-complementary distribution\ мөн ямарваа хоёр элементийн нэг нь нөгөөгийнхөө байранд тохиолдох шинжийг нь үл нөхөх байрлал \контрастирующая дистрибуция-contrastive distribution\ гэж ялган нэрлэж байна. Өөрөөр хэлбэл, хэлний нөхөх байрлалд тохиолдох хоёр элемент нь нэг нэгжийн утга үл ялгах хоёр хувилбар байж, үл нөхөх байрлалд тохиолдох хоёр элемент нь тус тусдаа утга ялгах биеэ даасан хоёр нэгж байна гэсэн үг болно. Дурдсан энэ зарчмыг монгол хэлний материал дээр авч үзвэл монгол хэлний b, w хоёр авиа нь abbāl, awād, nom báēnā, xā-wāēnā гэх мэтчилэн нэг нь нөгөөгийнхөө байранд үл тохиолдоод, бас зохих үг морфемын утгыг ялгахад үл оролцох учир нөхөх

* Ш.Лувсанвандан, *Хэлний нөхөх, үл нөхөх байрлалын тухай асуудалд*, “Монголын судлал”, YII боть, Улаанбаатар, 1969, 201-212-р тал.

байрлалд байгаа нэг В фонемын хоёр хувилбар болж, b, w хоёр авиа нь bāēnā, wāēnā гэх мэтчилэн нэг нь нөгөөгийнхөө байранд тохиолдоод, бас зохих үг морфемынхоо утгыг ялгахад оролцох учир үл нөхөх байрлалд байгаа b, w гэсэн тус тусдаа биеэ даасан хоёр фонем болно. Үүнчлэн монгол хэлний āg, ēg гэсэн утгат хоёр элемент нь garār, gerēr гэх мэтчилэн нэг нь нөгөөгийнхөө байранд үл тохиолдоод бас нэг зүйлийн харьцааны утга илтгэх учир нөхөх байрлалд байгаа үйлдэхийн тийн ялгалын нэг нөхцлийн хоёр хувилбар болж, āg, ās гэсэн хоёр элемент нь garār, garās гэх мэтчилэн нэг нь нөгөөгийнхөө байранд тохиолдоод бас хоёр өөр харьцааны утга илтгэх учир үл нөхөх байрлалд байгаа үйлдэх, гарахын хоёр өөр тийн ялгалын нөхцөл болно. Энэ жишээгээр хэлний хоёр авиа буюу хоёр утгат хэсгийг нөхөх байрлалд буюу эс нөхөх байрлалд байгаагаар нь үндэс болгож тэр хоёр авиа нь нэг фонемын хоёр хувилбар буюу эсвэл тус тусдаа биеэ даасан хоёр өөр фонем болох мөн хоёр өөр утгат хэсэг нь нэг морфемын хоёр хувилбар буюу эсвэл тус тусдаа биеэ даасан хоёр өөр морфем болохыг олонхи тохиолдолд зөв ялган тогтоож болох юм. Гэвч Зөвлөлтийн хэл шинжлэлтэн С.К.Шаумян хэлний хоёр авиа харилцан нөхөх байрлалд байвч тус тусдаа хоёр фонем байж, мөн харилцан үл нөхөх байрлалд байвч нэг фонемын хоёр хувилбар байж болдог нөхөх байрлалын зарчим дээр үндэслэж ямарваа хоёр авиа нэг авианы хоёр хувилбар буюу эсвэл тус тусдаа биеэ даасан хоёр өөр фонем болохыг тогтоох үндэс алга гэж шүүмжилж байна (С.К.Шаумян, “Проблемы теоретической фонологии” Москва, 1962, 98-100 дахь талд нь үз). Энэ шүүмжлэлийг монгол хэлний баримтаар шалган үзвэл америкийн хэл шинжлэлтний нөхөх байрлалын зарчмын тухай анхны томьёололд дутагдалтай газар байгаа нь илэрхий мэдэгдэж байна. Жишээлбэл: монгол хэлний хойгуурх а (bar[^], xar[^]), хэлний дундуурх ā/bārī, хāgī/ хоёр авиа нь нэг нь нөгөөгийнхөө байранд үл тохиолдох нөхөх байрлалд байж, үг морфемын утга ялгах учир нэг богино а фонемын хоёр хувилбар болох боловч монгол хэлний хэлний хойгуурх, эс уруулшсан а, уруулшсан о хоёр авиа нь ганц үет үгэнд (gal, gol) нэг нь нөгөөгийнхөө байранд тохиолдох үл нөхөх байрлалд байж, олон үет үгэнд бол (galāl, golōl) гэж нэг нь нөгөөгийнхөө байранд үл тохиолдох нөхөх байрлалд байгаад, хэлний хойгуурх эс уруулшсан а, хэлний дундуурх уруулшсан о хоёр нь (xawār, xowōg гэж) нэг нь нөгөөгийнхөө байранд хэзээ ч үл тохиолдох нөхөх байрлалд байвч, монгол хэлэнд а, о хоёр авиа нь хос хосоороо нэг фонемын хоёр хувилбар биш, харин тус тусдаа үг морфемын утга ялгах хоёр өөр фонем болж байна. Гэвч монгол хэлний нэг фонемын нэг хувилбар нь нөгөөгийнхөө байранд, цэвэр нэг нутгийн аялгуунд тохиолдохгүй, зөвхөн хоёр нутгийн аялгууг хольж хэлэх буюу нутгийн аялгууг бичгийн хэлтэй хольж хэлэх үед хааяа үзэгдэж магадгүй юм.

Энд бид америкийн байрлал хэл шинжлэлтний гаргасан нөхөх байрлалын (complementary distribution) анхны томьёололд ямар дутагдал байгааг олж, энэ зарчмыг шинээр томьёолохыг оролдъё.

Байрлал (дистрибуци) гэсэн ухагдахууныг хэлэнд хэлний нэг нэгжийн олон хувилбарын хоорондын харьцаа, хэлний нэгжийн ангиудын хоорондын харьцааны тогтолцоо байрлалт гэсэн утгаар хэрэглэх саналтай байна. Ямар нэг хэлний янз бүрийн нэгж, тэдгээрийг ангилах тухай асуудал бол уул хэлний янз бүрийн нэгж, тэдгээрийн ангийн бүтцийн тухай асуудал юм. Ертөнцөд аливаа юм, үзэгдэл цөм бүтэцтэй байдаг бол хэлний олон нэгж, тэдгээрийн анги бүлэг ч нэг адил бүтэцтэй байх учиртай нь мэдээж хэрэг юм. Жишээлбэл, монгол хэлний авиаг авиазүйн түвшинд авч үзвэл салангид авиа, тэдгээрийн анги, авиалбарзүйн түвшинд бол салангид фонем тэдгээрийн

анги, морфемзүйн түвшинд бол салангид морфем, тэдгээрийн анги, үгэлбэрзүйн түвшинд бол салангид үгэлбэр, тэдгээрийн анги гэх мэтчилэн янз бүрийн нэгж, ангид хуваагдаад салангид авиа нь жишээлбэл, ts гийгүүлэгч нь хамжиж эхлээд шүргэж төгсөх хоёр ажиллагаанаас бүрэлдэж, авианы нэг анги нь жишээлбэл, эгшгийн анги нь богино эгшиг, урт эгшиг, богино эгшгийн анги нь тод, тод бус, урт эгшгийн анги нь цэвэр урт, хос урт эгшгийн салбарласан ангиудаас бүрэлдсэн, салангид фонем нь жишээлбэл, монгол хэлний В фонем нь b, w хоёр үндсэн хувилбараас, b хувилбар нь цаашид эс тагнайшсан b, тагнайшсан b' хоёр хувилбараас, эс тагнайшсан b хувилбар нь дуутай b, дуугүй ɓ хоёр хувилбараас дам дам бүрэлдээд гийгүүлэгч фонемын анги нь сул гийгүүлэгч, чанга гийгүүлэгч фонемын ангиас бүрэлдэх мэт.

Ямар ба юм, үзэгдэл нь бие биеэ үгүйсгэхийн зэрэгцээгээр бие биеэ нөхөх хоёр талын нэгдэл буюу дундаж байдалд байж, тэр нэгдэл буюу дундаж байдал нь уул юм, үзэгдлийн ерөнхий буюу хийсвэр чанар болж, түүний эсрэг тэсрэг хоёр тал нь зохих юм, үзэгдлийг бүрэлдүүлэх тусгай бодтой тал нь боловч ямар ба юм, үзэгдэл нь бусад юм, үзэгдэлтэйгээ шууд буюу шууд бусаар шүтэн барилдаж байдаг учир уул юм, үзэгдэл нь өөрийн анги, бүлгийн гишүүний хувьд бол ямагт тусхай, бодтой зүйл болдог буюу өөрөөр хэлбэл, нэг харьцаанд ерөнхий хийсвэр чанар байсан нь нөгөө харьцаанд тусхай, бодтой зүйл болж, ерөнхий нь ямагт тусгайгаараа илэрч тусгай нь ямагт ерөнхийнхөө бүрэлдэхүүнд багтан, хийсвэр чанар нь ямагт бодтой оршиж, бодтой зүйл нь ямагт хийсвэр чанарыг хадгалж, тусгайгаасаа ангид ерөнхий, ерөнхийгөөсөө ангид тусгай, бодтойгоосоо ангид хийсвэр чанар, хийсвэр чанаргүй бодтой зүйл гэж ертөнцөд ерөөсөө байдаггүй гэж үздэг диалектикийн ерөнхий хууль нь хэлний янз бүрийн нэгжийн бүтэц, тэдгээрийн анги, бүлгийн харьцаанд нь илэрхий харагдана.

Орчин цагийн монгол хэлний b фонем нь юуны өмнө хамжих b, шүргэх w хувилбараар илэрч, энэ хоёр хувилбар нь хамжих, шүргэх шинжээрээ бие биеэ үгүйсгэхээс гадна b-гийн тохиолдох байранд w нь үл тохиолдох учир бас байрлалаараа нэг нь нөгөөгөө нөхөн нэгдэж нэг b фонемын хоёр хувилбар болж чадна. Цаашид хамжих b хувилбар нь эс тагнайшсан b, тагнайшсан b' шинжээрээ харилцан бие биеэ үгүйсгэхээс гадна бас байрлалаараа харилцан бие биеэ үгүйсгэвч бие биеэ харилцан нөхөж, нэг b фонемын b хувилбарын хоёр хувилбар болно. Гэвч В, М хоёр фонем нь эс хамаршсан, хамаршсан шинжээрээ харилцан бие биеэ үгүйсгэвч байрлалаараа бие биеэ үл үгүйсгэх учир бие биеэ нөхөж, хэлний дохионы тэмдгийн нэг нэгж болох буюу нэг фонемын хоёр хувилбар болохгүй, тус тусдаа биеэ даасан хоёр фонем болно. Жишээлбэл, bal, mal гэх мэт. Гэтэл дурдсан хоёр фонем нь монгол хэлний гийгүүлэгч фонемын ерөнхий ангийн доторх уруулшсан гийгүүлэгч фонемын тусгай ангийн гишүүний хувьд бол харилцан бие биеэ нөхөж хамтдаа нэг салбар анги болно.

Үүнчлэн орчин цагийн монгол хэлний нэрийн тийн ялгалын нэг нөхцлийн олон хувилбар нь фонемынхоо бүтэц, байрлалаараа харилцан бие биеэ үгүйсгэвч гүйцэтгэх үүргээрээ бие биеэ нөхөж, нэг зүйлийн тийн ялгалын нөхцөл болдог байна. Гэвч нэрийн олон зүйлийн тийн ялгалын нөхцөл нь фонемынхоо бүтцээр харилцан бие биеэ үгүйсгэвч нэг нэрийн үндсэнд нэрийн тийн ялгалын бүх нөхцөл тохиолдож болдог учир байрлалаараа бие биеэ үгүйсгэх үл нөхөх байрлалд байдаг байна. Гэтэл нэрийн тийн ялгалын ай нь бүхэлдээ нэрийн үндсийн дараа тохиолдож, үйл үгийн үндсийн дараа үл тохиолдох, үйлийн тийн ялгалын ай нь бүхэлдээ үйл үгийн үндсийн дараа тохиолдож, нэрсийн үндсийн дараа үл тохиолдох учир энэ хоёр зүйлийн тийн ялгалын ай буюу анги нь фонемынхоо бүтцээр, мөн байрлалаараа харилцан бие биеэ үгүйсгэвч түрүүчийнх нь

үгийг сүүлчийнх нь үгэнд захируулах хэлний дохионы хувьд хамтдаа нэг тийн ялгалын ай буюу анги болох юм. Цаашид ерөнхий тийн ялгалын нөхцлийн ай нь мөн ерөнхий хамаатуулахын айтай эсрэгцэхдээ хамтдаа үгийн нөхцлийн бүр ерөнхий айг бүрэлдүүлээд энэ үгийн ерөнхий нөхцлийн ай нь үг бүтээх дагавар морфемын ерөнхий айтай эсрэгцэлдэж нийт залгавар морфемын ай болж, залгавар морфемын анги нь ерөнхий язгуур морфемын айтай эсрэгцэлдэж хамтдаа ерөнхий хийсвэр морфем гэсэн ухагдахуун болно.

Энэ мэтээр хэлний ямар нэг нэгж буюу тэдгээрийн анги нь харилцан бие биеэ үгүйсгэхийн зэрэгцээгээр харилцан бие биеэ нөхөх эсрэг тэсрэг хоёр талаас бүрэлдсэн байдаг байна. Өөрөөр хэлбэл, хэлний ямар нэг нэгж буюу анги нь дотроо зөрчилтэй, бас нэгдэлтэй байдаг гэсэн үг болно. Дотроо дан ганц зөрчилтэй эсвэл дан ганц нэгдэлтэй хэлний тийм нэгж буюу анги (ай) гэж байж болохгүй юм. Заавал зөрчил, нэгдэл хоёр хосолж байж сая хэлний ямар нэг нэгж буюу нэгжүүдийн анги бүрэлдэх ёстой ажээ. Жишээлбэл, фонем, морфемын дотоод зөрчил нь түүний олон хувилбараар илэрч дотоод нэгдэл нь хэлний тэмдгийн нэг нэгж (фонем), хэлний дохионы нэг нэгж (морфем) болдгоор нь илэрнэ. Үүнчлэн фонемын анги, морфемын ангийн дотоод зөрчил нь тэр ангид багтсан фонем, морфемоор илэрч, дотоод нэгдэл нь тэдгээр олон фонем, морфем тус тус нийлэн, нэг ерөнхий анги болдгоор нь илэрнэ. Фонем, морфем нь хэлний нэгжийн хувьд өөр өөрийн хувилбарын талаас ерөнхий, хийсвэр ухагдахуун болж, түүний хувилбарууд нь тусхай бодтой тал болох боловч мөнхүү фонем, морфем нь өөр өөрийн анги бүлгийн гишүүний хувьд тусхай бодтой зүйл болж харин тэр анги бүлэг нь ерөнхий хийсвэр ухагдахуун болно. Нэг үгээр хэлбэл, мөнхийн ерөнхий, хийсвэр буюу тусхай, бодтой гэж байхгүй, цөм харьцангуй юм.

Энэ учраас бид америкийн байрлал хэл шинжлэлтний нөхөх байрлалын зарчмын тухай анхны томьёололд хэлний чухал нэгжүүд болох фонем морфемын хувилбарын хоорондын харьцааг дан ганц тэдний нэг нь нөгөөгөө үгүйсгэх зөрчлийн талаас харж, нэг нь нөгөөгөө нөхөж нэг зүйлийн нэгж болгодог нэгдлийн нь талыг орхисон ноцтой дутагдал байна гэж бодож байна. Жишээлбэл, америкийн хэл шинжлэлтэн Г.Глисон морфемын олон хувилбарыг ангилахдаа: "Хоёр элемент нь (1) ямар нэг ерөнхий дундын утгатай, бас (2) ямар нэг авиалбарзүйтэй нөхцөлдсөн нөхөх байрлалд байвал нэг адил морфем гэж үзэж болно. Хоёр элемент нь нэгийнхээ тохиолдох орчинд нөгөө нь хэрхэвч тохиолдохгүй байвал нөхөх байрлалд байна гэж хэлж болно" (H.A. Gleason, An Introduction to Descriptive Linguistics, New York, 1959, 80 дахь талд үз) гэж бичсэн байна. Дээр дурдсан Г.Глисоны томьёоллыг бид, "Хоёр элемент нь нөхөх байрлалд байвал нэг морфемын хоёр хувилбар, үл нөхөх байрлалд байвал хоёр өөр морфем гэж үзэж болно. Хоёр элемент нь хэлбэр, байрын талаар харилцан бие биеэ үгүйсгэвч гүйцэтгэх үүргийн талаар харилцан бие биеэ нөхөж байвал нөхөх байрлалд, хэлбэр байрын талаар харилцан бие биеэ үгүйсгэвч гүйцэтгэх үүргийнхээ талаар харилцан бие биеэ нөхөхгүй байвал үл нөхөх байрлалд байна гэж болно. Хоёр элемент нь хэлбэр байрын аль аль талаар буюу эсвэл дан хэлбэр, дан байрын талаар харилцан бие биеэсээ ялгарч байвал харилцан бие биеэ үгүйсгэж байна, нэг нь нөгөөгүйгээр байж болохгүй буюу өөрөөр хэлбэл, нэг бүхэл зүйлийн эсрэг тэсрэг хоёр тал шинжтэй байвал харилцан бие биеэ нөхөж байна гэж хэлж болно" гэж засамжлах хүсэлтэй байна. Хэрэв ингэж засвал энэ нөхөх, үл нөхөх байрлалын зарчим нь хэлний янз бүрийн нэгж, тэдгээрийн анги бүлгийг ялган тогтоох чухал арга болж чадна гэж бодож байна.

Монгол хэлний баримтаас үзэхэд салангид фонемууд нь бие биеэсээ дан хэлбэрээрээ, заримдаа хэлбэр, байр хоёроороо, хааяа дан байраараа ялгардаг бол нэг фонемын олон хувилбар нь хэлбэр, байр хоёроороо бие биеэсээ ялгардаг ажээ. Жишээлбэл, *nal*, *mal* гэхэд тохиолдох эхний *n*, *m* хоёр фонем нь дан ганц эс уруулшсан, уруулшсан хэлбэрээрээ бие биеэсээ ялгарч, *ende mal olöm bāēnā*, *endē emēlīŋ olöm bāēnā* гэхэд олон, олом гэсэн хоёр үгийн эцсийн *n*, *m* хоёр фонем нь хэлбэрийн ялгавар байхгүй болж, зөвхөн байраараа ялгарна. Ингэж олон гэсэн үгийн эцсийн *n* фонем *b*-гээр эхэлсэн үгийн өмнө *m* болох боловч *olon temē*, *olōŋ xūn* гэх мэтээр *t*-гээр эхэлсэн үгийн өмнө *n* болж, *x*-гээр эхэлсэн үгийн өмнө *ŋ* болдог бол үгийн эцсийн *olöm* бүх нөхцөлд хэвээрээ байдаг нь цэвэр байраараа ялгарахын жишээ болно. Гэвч *garāl*, *gerēl* гэхэд тохиолдох *a*, *e* хоёр фонем, *abbāl*, *awād* гэхэд тохиолдох нэг фонемын хоёр хувилбар болох *b*, *w* хоёр нь хэлбэр, байр хоёроороо бие биеэсээ ялгарч байна.

Үүнчлэн салангид морфемууд нь бие биеэсээ дан хэлбэрээрээ заримдаа хэлбэр, байр хоёроороо хааяа дан байраараа ялгардаг бол нэг морфемын олон хувилбар нь хэлбэр, байр хоёроороо бие биеэсээ ялгардаг ажээ. Жишээлбэл: *gar*, *ger* гэсэн хоёр морфем нь эр эгшигт, эм эгшигтэй хэлбэрээрээ бие биеэсээ ялгарч, *xaḡ*(нэр үг) *gaḡ*^(үйл үг) гэсэн хоёр морфем нь хэлбэр, байр хоёроороо бие биеэсээ ялгараад, *xaḡ* (нэр үг), *xaḡ* (үйл үг) гэсэн хоёр морфем нь дан ганц байраараа ялгарч үйлдэхийн тийн ялгалын нэг нөхцөл морфемын хоёр хувилбар болох *-āḡ*, *-ēḡ* хоёр нь хэлбэр, байр хоёроороо бие биеэсээ ялгарах мэт хоёр фонем, хоёр морфем буюу нэг фонем, морфемын хоёр хувилбарын бие биеэсээ хэлбэр байраараа ялгарах гэдэг нь харилцан бие биеэ хэлбэр, байраараа үгүйсгэх гэсэн үг юм. Хэлний аливаа хоёр элементийн хэлбэрийн ялгавар нь гарах авианы нь ялгавар дээр үндэслэж, мөн байрын ялгавар нь уул хоёр элемент нь адил орчинд тохиолдох эсэх дээр үндэслэдэг байна. Цаашид үг, үгэлбэр, жич фонем, морфем, үг, үгэлбэрийн ерөнхий, салбар ангиудын хоорондын харьцаа нь дээрхтэй нэг жишээтэй юм.

Фонем фонемын анги, морфем, морфемын анги, үг, үгийн анги, үгэлбэр, үгэлбэрийн анги гэдэг нь цөм нэг нь нөгөөгүй байж болохгүй бие биеэ харилцан үгүйсгэхийн зэрэгцээгээр мөн нөхөх хоёр эсрэг тэсрэг талын ерөнхий хийсвэр, дундаж байдал нь болж эсрэг тэсрэг хоёр тал нь тухай тухайн нэгж буюу ангийн тусхай, бодтой хоёр тал нь болно. Хэлний янз бүрийн нэгж, тэдгээрийн олон анги нь дам дам хос хосоороо шаталсан шинжтэй байна. Жишээлбэл, фонем, фонемын хувилбар, бас хувилбарын нь хувилбар, морфем, морфемын хувилбар, бас хувилбарын нь хувилбар, морфемын анги бас түүний салбар анги, үг, үгийн хувилбар, үгийн анги, бас түүний салбар анги гэх мэтчилэн шаталсан байна. Энэ учраас фонемын түвшинд фонемууд нь харилцан бие биеэ үл нөхөх ерөнхий хийсвэр, бүхэл зүйл байдаг бол фонемынхоо ангийн түвшинд фонемууд нь харилцан бие биеэ нөхөх тусхай, бодтой нэг бүхлийн хэсгүүд байж, морфемын түвшинд морфемууд нь харилцан бие биеэ үл нөхөх ерөнхий, хийсвэр, бүхэл зүйл байдаг бол морфемынхоо ангийн түвшинд морфемууд нь харилцан бие биеэ нөхөх тусхай, бодтой, бүхлийн хэсгүүд болоод тэр фонем, морфемын ангиуд нь ерөнхий хийсвэр, бүхэл зүйл болох боловч түүний давхарласан өөр өөрийн бүр ерөнхий, хийсвэр ангийн бүрэлдэхүүнд орохдоо бас харилцан бие биеэ нөхөх тусхай бодтой салбар ангиуд болно. Энэ мэтээр хэлний нөхөх үл нөхөх байрлалын зарчим гэдгийг бодтой харьцаанд илрэх харьцангуй зүйл гэж үзэх хэрэгтэй байна.

Фонемууд нь хэлбэр, байрын ялгавар дээр үндэслэн үүссэн, хэлний дохионы янз бүрийн тэмдгийн үүрэг гүйцэтгэх салангид нэгжүүд байдаг бол нэг фонемын хувилбарууд нь хэлбэр байрын ялгавар дээр үндэслэн бие биеэсээ ялгаравч хэлний дохионы нэг зүйлийн тэмдгийн үүрэг гүйцэтгэх нэг нэгж байдаг ажээ. Энэ учраас нэг морфемд нэг фонем буюу нэг фонемын хоёр хувилбар шууд залгаж давтан орж болдоггүй байна. Үүнчлэн морфемууд нь хэлбэр, байрын ялгавар дээр үндэслэн үүссэн, хэлний янз бүрийн дохионы үүрэг гүйцэтгэх салангид нэгжүүд байдаг бол нэг морфемын хувилбарууд нь хэлбэр, байрын ялгавар дээр үндэслэж бие биеэсээ ялгаравч хэлний нэг зүйлийн дохионы үүрэг гүйцэтгэх нэг нэгж байдаг ажээ. Энэ учраас нэг үгэнд нэг морфем буюу нэг морфемын хоёр хувилбар шууд залгаж давтан орж болдоггүй байна. Хэрэв нэг морфемд нэг зүйлийн фонем шууд залгалдан орох буюу нэг үгэнд нэг зүйлийн морфем шууд залгалдан орвол уул фонем, морфем нь хэлний дохионы тэмдгийн хоёр нэгж буюу дохионы хоёр нэгж болж чадахгүй юм. Өөрөөр хэлбэл, нэг зүйлийн фонем, морфем нь байрын талаар өөрөө өөрийгөө үгүйсгэдэг ажээ.

Хэлний аливаа хоёр элемент нь хэлбэр байрын талаар харилцан бие биеэ үгүйсгэвч нэг нь нөгөөгүйгээр байж болохгүй, нэг бүхэл зүйлийн хоёр тал болж харилцан бие биеэ нөхөж байвал тэр хоёр элемент нь заавал нэг ерөнхий дундаж утга, үүрэгтэй байдаг байна. Дээр дурдсан ёсоор Г.Глисон морфемын хувилбарыг ангилахдаа 1\ хэлний хоёр элемент нь нэг ерөнхий дундаж утгатай, 2\ нөхөх байрлалд байвал нэг морфемын хоёр хувилбар байна гэсэн нь уул хоёр элементийн нэг ерөнхий дундаж утгатай болдгийг нөхөх байрлалаас нь салгаж, нөхөх байрлалын зарчмыг дан ганц хоёр элементийн харилцан бие биеэ үгүйсгэх гэсэн утгаар хэрэглэсэн байна. Хэрэв нөхөх байрлалын зарчмыг дээр дурдсан ёсоор шинээр томъёолбол, морфемын хувилбарыг ангилахад Г.Глисоны хоёр элемент нэг ерөнхий дундын утгатай байвал гэсэн нэг зүйл нь илүүц зүйл болж аяндаа нөхөх байрлалын зарчмын нэг тал нь болох ёстой болно. Хэрэв нөхөх байрлал гэж байвал түүний эсрэг үл нөхөх байрлал гэж байх ёстой болно. Аливаа хоёр элемент нь нэг талаар хэлбэр байраараа харилцан бие биеэ үгүйсгэж, нөгөө талаар харилцан бие биеэ нөхөх буюу эсвэл үл нөхөх хоёр шинжтэй байдаг байна. Хоёр элемент нь тухайн түвшинд бие биеэ нөхөж байвал нэг зүйлийн хоёр тал болж, бие биеэ нөхөхгүй байвал тус тусдаа хоёр зүйл болно. Энд бид нөхөх /дополнительный-Complementary principle/ гэсэн үгийг алдарт физикч Нильс Борын нөхөх зарчим /Complementary principle/-д хэрэглэсний адил утгаар хэрэглэсэн билээ.

SUMMARY

Contribution to the Complementary and Noncomplementary Distribution in language

In this paper the author tries to give a new definition of complementary and non-complementary distribution in language. Up to the present it was understood amongst linguists as the infra given definition by Professor H.A.Glaeson, an eminent American scholar; "... Two elements can be considered as the same morpheme if (1) they have some common range of meaning, and (2) they are in complementary distribution conditioned by some phonologic feature.

Two elements are said to be in complementary distribution if each occurs in certain environments in which the other never occurs – that is, if there are no environments in which both occur...”.

The author, having studied the above definition thoroughly, found out that in the definition the entire attention was paid solely to the mutually exclusive feature of the two elements, not taking into account their complementary relationship. So the author, considering the above-mentioned definition inadequate, gives his own definition: two elements can be considered as the same phoneme or morpheme if they are in complementary distribution; they are different phonemes or morphemes if they are in non-complementary distribution.

Two elements are said to be in complementary distribution, if each is mutually exclusive at the same time mutually complementary (if we use the Niels Bohr's complementary principle in linguistics), and in non-complementary distribution, if each is mutually exclusive (in form or position or in both), but not mutually complementary.

According to this definition the phoneme, morpheme, word, sentence, their classes and sub-classes – all are the general, the abstract, the middle condition of the two oppositions which are mutually exclusive and at the same time mutually complementary, and quite the reverse, the oppositions are the particular, concrete manifestation of the phoneme, morpheme, word, sentence or their classes and sub-classes respectively.

In this connection linguistic phenomena are not an exception to the general law of universe. A linguistic unit and its class are in hierarchical structure, for example phoneme, allophone, suballophone and thephoneme class; morpheme, allomorph, sub-allomorph, and morpheme class, morpheme sub-class; word, allolog, word class and word sub-class. They are in binary principle as well; phoneme or morpheme consists of allophones or allomorphs, in turn, each allophone or allomorph consists of sub-allophones or sub-allomorphs.

Therefore at the phoneme level phonemes are mutually noncomplementary, general, abstract, whole, but at the phoneme class level phonemes are mutually complementary, particular, concrete, parts of a whole; at the morpheme level morphemes are mutually non-complementary, general, abstract, whole, but at the morpheme class level morphemes are mutually complementary, particular, concrete, parts of a whole. So the author has come to the conclusion that the principle of complementary and non-complementary distribution is a relative phenomenon which occurs in concrete relations.